

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	2
2. Аудитын тайлан.....	4
2.1. Оршил	4
2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	4
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	5
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	5
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	6
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	6
2.10. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	7
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	7
2.12. Шилэн дансны мэдээлэл.....	7
2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	7
2.14. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	7
3. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	8
3.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	8
3.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	9
3.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	10
3.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	13

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

АРВАН АЙМГИЙН ДУЛААНЫ СТАНЦ
БАРИХ ТӨСЛИЙН ЗОХИЦУУЛАГЧ
Г.МӨНХЦООДОЛ ТАНАА

2020.03.13 № 06/838
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Арван аймгийн дулааны станц барих төслийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Арван аймгийн дулааны станц барих төслийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, стандарт болон холбогдох хууль тогтоомжийн дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Арван аймгийн дулааны станц барих төслийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг хариуцлага


Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

В. Р.

Ц.НАРАНЧИМЭГ



2. Аудитын тайлан

2.1. Оршил

Арван аймгийн төвийн дулааны станц барих төслийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Арван аймгийн төвийн дулааны станц барих төслийн зохицуулагч Г.Мөнхцоодол Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Арван аймгийн төвийн дулааны станц барих төслийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Арван аймгийн төвийн дулааны станц барих төслийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 2 дугаар сарын 28-наас 2020 оны 3 дугаар сарын 10-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 3 дугаар сарын 12-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын захиалгаар Нийслэл аудит ХХК-ийн чанарын хяналтын менежер С.Сэрчхорол, аудитор Д.Ариунбулган, аудиторын туслах Ц.Гантуяа нар хариуцан хэрэгжүүлэв.

Арван аймгийн төвийн дулааны станц барих төсөл нь 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Санхүүгийн аудитын газарт 2020 оны 1 дүгээр сарын 23-ны өдрийн №А/10 дугаар албан бичгээр ирүүлсэн байна. Харин Нийслэл аудит ХХК-д 2020 оны 3 дугаар сарын 5-ны өдрийн №А/30 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Тус төсөл нь Төв, Дундговь, Хэнтий, Өвөрхангай, Говь-Алтай, Завхан, Архангай, Баянхонгор, Говьсүмбэр, Сүхбаатар зэрэг арван аймгийн төвд дулааны станц, дулаан дамжуулах сүлжээ, дулаан дамжуулах төвүүд барьж байгуулах, өргөтгөх зорилгоор Монгол улсыг төлөөлөн Сангийн яам болон Бүгд Найрамдах Солонгос Улсын Эксим банкны хооронд

2018 оны 12 дугаар сарын 17-ний өдөр байгуулсан №NO.MON-14 тоот зээлийн гэрээний дагуу төслийн үйл ажиллагааг эрхлэн явуулахаар байгуулагдсан. Арван аймгийн төвийн дулааны станц барих төсөл нь үйл ажиллагааны эрхэм зорилгоо Дулааны станц бүхий төвлөрсөн дулаан хангамжийн систем барьж байгуулах, дулааны станц бүхий төвлөрсөн дулаан хангамжийн системийн үр ашгийг сайжруулах, өсөн нэмэгдэж буй дулааны ачаалалд нийцүүлэн дулааны эх үүсвэрийг өргөтгөх, хэрэглэгчдийг жилийн турш хэрэгцээний халуун усаар хангах, хэрэглэгчдийн сэтгэл ханамжийг сайжруулах, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг сайжруулах гэж тодорхойлон ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Арван аймгийн төвийн дулааны станц барих төслийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Арван аймгийн төвийн дулааны станц барих төсөл нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд Acolous программ хангамж ашигладаг байна.

Арван аймгийн төвийн дулааны станц барих төслийн дотоод хяналтыг гүйцэтгэлийн шатанд хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Арван аймгийн төвийн дулааны станц барих төслийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг бага гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Арван аймгийн төвийн дулааны станц барих төслийн нийт орлогод зээлийн санхүүжилт дийлэнх хувь эзэлдэг тул нийт зардлын хэмжээ нь үйл ажиллагааны цар хүрээг илтгэх тохиромжтой үзүүлэлт гэж үзэн материаллаг байдлын суурь болгон сонголоо.

Төлөвлөлтийн материаллаг байдлын түвшнийг 2019 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2 хувь болох 109,964.9 мянган төгрөгөөр тооцлоо.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг дахин тооцоолоогүй болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөг/
			Өөрчлөлт
Мөнгөн хөрөнгө		-	-
Авлага		60.0	(60.0)
Урьдчилгаа		-	-
Бараа материал		665.5	(665.5)
Үндсэн хөрөнгө		83,206.6	(83,206.6)
Нийт хөрөнгө		83,932.1	(83,932.1)
Өр төлбөр		60.0	(60.0)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/		83,872.1	(83,872.1)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн		83,932.1	(83,932.1)

Авлага дансанд тус төслийн ажиллагсдаас авах хувь хүний орлогын албан татварын авлага байна.

Бараа материалын дансанд тус төслийн үйл ажиллагаанд шаардлагатай ашиглалтад байгаа хангамжийн материал байна.

Үндсэн хөрөнгө дансанд төслийн үйл ажиллагаа эхлэхтэй холбогдуулан худалдаж авсан шаардлагатай хөрөнгө болох тавилга, эд хогшил, компьютер, дагалдах хэрэгсэл бүртгэлтэй байна.

Өр төлбөр дансанд татварын байгууллагад өгөх татварын өглөг бүртгэлтэй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 83,932.1 мянган төгрөг болсон нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх Арван аймгийн төвийн дулааны станц барих төсөл хөтөлбөрт зориулан 5,554,875.8 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 5,554,875.8 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Гүйцэтгэлээр 5,554,875.8 мянган төгрөгийн санхүүжилт бүрэн олгогдож, урсгал зардалд 5,537,308.2 мянган төгрөгийг зарцуулж 17,567.6 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Тус төсөл нь Төв, Дундговь, Хэнтий, Өвөрхангай, Говь-Алтай, Завхан, Архангай, Баянхонгор, Говьсүмбэр, Сүхбаатар зэрэг арван аймгийн төвд дулааны станц барих зорилгоор Монгол улсыг төлөөлөн Сангийн яам болон Солонгос улсын Экспорт-импортын банкны хооронд 2018 оны 12 дугаар сарын 17-ний өдөр байгуулсан №NO.MON-14 тоот зээлийн гэрээний дагуу төслийн үйл ажиллагааг эрхлэн явуулахаар байгуулагдсан байна. Төслийн нийт үнэлгээ 148,721.0 ам.доллар бөгөөд 2019 оны 7 дугаар сарын 31-ний өдөр байгуулсан ЕНА-014/2019 тоот Зөвлөх үйлчилгээний гэрээний дагуу урьдчилгаа төлбөр болох 2,487,760.9 мянган төгрөг, мөн төслийн ерөнхий зураг төсөв хүлээлцсэн 2019 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 01 тоот актыг үндэслэн дараагийн төлбөр болох 2,541,842.6 мянган төгрөг нийт 5,029,603.5 сая төгрөгийг Солонгос улсын "KDH" компанид гэрээний дагуу төлсөн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 5,537,308.2 мянган төгрөг буюу 99.0 хувьтай байгаа нь шуудан холбоо, тээвэр шатахуун зэрэг зардлыг хэмнэсэнтэй холбоотой байна.

2.10. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг гүйцэтгэх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 3 чиглэлээр аудитын 4 горим сорил гүйцэтгэж үнэлэхэд алдаа зөрчилтэй асуудал гараагүй ба аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийгдээгүй болно.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Тайлант онд тус төсөл зөвлөх үйлчилгээний төлбөрт 5,029,603.5 мянган төгрөгийн зарцуулалт хийсэн бөгөөд энэ нь нийт урсгал зардлын 90,5 хувийг эзэлж байгаа ба дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Арван аймгийн төвийн дулааны станц барих төсөл нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй. Тайлант жилд шилэн дансны цахим хуудсанд нийт 85 төрлийн мэдээллийг байршуулахаас 84 мэдээ цаг хугацаанд нь байршуулж, 1 мэдээг хугацаа хожимдуулан байршуулсан байна.

2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Тус төсөл 2019 оны 5 дугаар сард үүсгэн байгуулагдаж үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн тул өмнөх санхүүгийн тайлангийн аудит хийгдээгүй зөвлөмж байхгүй болно.

2.14. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Арван аймгийн төвийн дулааны станц барих төслийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Арван аймгийн төвийн дулааны станц барих төслийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. Аудит хийсэн санхүүгийн тайлан

3.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа 2019 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн дуусвар болсон санхүүгийн тайлан

/төгрөгөөр/			
Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	0.00	725,500.00
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	0.00	0.00
32	БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	00.00	00.00
33	АВЛАГА	0.00	60,000.00
33100	Байгууллагаас авах авлага		60,000.00
335	Бусад авлага	0.00	60,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	0.00	665,500.00
35470	Бусад хангамжийн материал	0.00	665,500.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	0.00	83,206,582.43
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	0.00	83,206,582.43
392	Биет хөрөнгө	0.00	82,424,360.19
39203	Авто тээврийн хэрэгсэл	0.00	64,101,505.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	0.00	(40,597,619.87)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	0.00	46,785,000.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	0.00	(3,990,916.68)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	0.00	16,497,080.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	0.00	(1,094,338.26)
39214	Бусад үндсэн хөрөнгө	0.00	846,500.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	00.00	(122,850.00)
393	Биет бус хөрөнгө	0.00	782,222.24
39303	Бусад биет бус хөрөнгө	0.00	880,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	00.00	(97,777.76)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	0.00	83,932,082.43
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0.00	60,000.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.00	60,000.00
413	Өглөг	0.00	60,000.00
4136	Бусад өглөг	0.00	60,000.00
41362	Хувь хүмүүст өгөх өглөг	0.00	60,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	0.00	83,872,082.43
51	Засгийн газрын хувь оролцоо	0.00	83,872,082.43
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	0.00	83,872,082.43
512	Хуримтлагдсан үр дүн	0.00	83,872,082.43
51220	Тайлант үеийн үр дүн	0.00	83,872,082.43
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	0.00	83,932,082.43

3.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа 2019 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн дуусвар болсон санхүүгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	0.00	5,582,118,980.10
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	0.00	5,056,846,680.10
120	Нийтлэг татварын бус орлого	0.00	5,056,846,680.10
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	0.00	5,029,603,540.50
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	0.00	27,243,139.60
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	0.00	525,272,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	0.00	525,272,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	0.00	525,272,300.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	0.00	5,498,246,897.67
21	УРСГАЛ ЗАРДАЛ	0.00	5,498,246,897.67
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0.00	5,480,679,272.67
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	0.00	43,102,452.00
210201	Тэтгэврийн даатгал	0.00	29,480,456.00
210202	Тэтгэмжийн даатгал	0.00	3,468,289.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	0.00	2,774,631.00
210204	Ажилгүйдлийн даатгал	0.00	670,826.00
210205	Эрүүл мэндийн даатгал	0.00	6,708,250.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	0.00	26,630,000.00
210304	Байрны түрээс	0.00	26,630,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	0.00	8,509,560.00
210401	Бичиг хэрэг	0.00	2,255,770.00
210402	Тээвэр, шатахуун	0.00	3,289,100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	0.00	2,964,690.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	0.00	500,000.00
210604	Урсгал засвар	0.00	500,000.00
2107	Томилолт, зочны зардал	0.00	13,001,200.00
210702	Дотоод албан томилолт	0.00	13,001,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	0.00	5,378,182,433.50
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.00	5,378,182,433.50
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	10,753,627.17
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	1,708,490.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	0.00	9,045,137.17
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	17,567,625.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.00	17,567,625.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	17,567,625.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	0.00	83,872,082.43
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	0.00	83,872,082.43

3.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа 2019 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн дуусвар болсон санхүүгийн тайлан /төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	0.00	5,554,875,840.50
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	0.00	5,029,603,540.50
120	Нийтлэг татварын бус орлого	0.00	5,029,603,540.50
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	0.00	5,029,603,540.50
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	0.00	5,029,603,540.50
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	0.00	525,272,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	0.00	525,272,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	0.00	525,272,300.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	0.00	5,489,867,260.50
21	УРСГАЛ ЗАРДАЛ	0.00	5,489,867,260.50
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0.00	5,472,299,635.50
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	0.00	43,102,451.00
210201	Тэтгэврийн даатгал	0.00	37,144,271.00
210202	Тэтгэмжийн даатгал	0.00	1,754,753.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	0.00	
210204	Ажилгүйдлийн даатгал	0.00	
210205	Эрүүл мэндийн даатгал	0.00	4,203,427.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	0.00	26,630,000.00
210304	Байрны түрээс	0.00	26,630,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	0.00	8,878,310.00
210401	Бичиг хэрэг	0.00	2,624,520.00
210402	Тээвэр, шатахуун	0.00	3,289,100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	0.00	2,964,690.00
	Эд хогшил, урсгал засварын зардал	0.00	500,000.00
210604	Урсгал засвар	0.00	500,000.00
2107	Томилолт, зочны зардал	0.00	13,001,200.00
210702	Дотоод албан томилолт	0.00	13,001,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	0.00	5,378,182,434.50
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.00	5,378,182,434.50
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	2,005,240.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	2,005,240.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	17,567,625.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.00	17,567,625.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	17,567,625.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	0.00	65,008,580.00
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.00	0.00

5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	0.00	65,008,580.00
22	Хөрөнгийн зардал	0.00	65,008,580.00
2200	Дотоод эх үүсвэрээр	0.00	65,008,580.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	0.00	65,008,580.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	0.00	<u>(65,008,580.00)</u>
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.00	<u>0.00</u>
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.00	<u>0.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	0.00	0.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

3.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа 2019 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн дуусвар болсон санхүүгийн тайлан

/ төгрөгөөр /

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	-	-	-
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт					
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					
Тайлант үеийн үр дүн					
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	-	-	-
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт					
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт					
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					
Тайлант үеийн үр дүн			83,872,082.43		83,872,082.43
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл			83,872,082.43		83,872,082.43

3.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа 2019 оны 12 дугаар 31-ны өдрийн дуусвар болсон санхүүгийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,554,875,840.50	5,537,308,215.50	17,567,625.00	99.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,554,875,840.50	5,537,308,215.50	17,567,625.00	99.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,554,875,840.50	5,537,308,215.50	17,567,625.00	99.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	44,393,700.00	43,102,451.00	1,291,249.00	97.0
210201	Тэтгэврийн даатгал	36,512,900.00	37,144,271.00	(631,371.00)	101.7
210202	Тэтгэмжийн даатгал	2,759,000.00	1,754,753.00	1,004,247.00	63.6
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,121,800.00		5,121,800.00	
210204	Ажилгүйдлийн даатгал				
210205	Эрүүл мэндийн даатгал		4,203,427.00	(4,203,427.00)	
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	26,630,000.00	26,630,000.00		100.0
210304	Байрны түрээс	26,630,000.00	26,630,000.00		100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	9,276,200.00	9,026,810.00	249,390.00	97.3
210401	Бичиг хэрэг	2,631,800.00	2,624,520.00	7,280.00	99.7
210402	Тээвэр, шатахуун	3,349,900.00	3,289,100.00	60,800.00	98.1
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,294,500.00	3,113,190.00	181,310.00	94.5
2106	Эд хогшил худалдан авах	64,480,100.00	64,480,080.00	20.00	100.0
210601	Багаж, техник хэрэгсэл	47,483,000.00	47,483,000.00		100.0
210602	Тавилга	16,497,100.00	16,497,080.00	20.00	100.0
210604	Урсгал засвар	500,000.00	500,000.00		100.0
2107	Томилолт, зочны зардал	17,678,000.00	13,001,200.00	4,676,800.00	73.5
210702	Дотоод албан томилолт	17,678,000.00	13,001,200.00	4,676,800.00	73.5
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,390,362,840.50	5,379,062,434.50	11,300,406.00	99.7
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,390,362,840.50	5,379,062,434.50	11,300,406.00	99.7
220103	Бараа, үйлчилгээний бусад зардал	2,055,000.00	2,005,240.00	49,760.00	97.5
210901	Бараа, үйлчилгээний бусад зардал	2,055,000.00	2,005,240.00	49,760.00	97.5
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	5,554,875,840.50	5,537,308,215.50	17,567,625.00	100.0
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	525,272,300.00	507,704,675.00	17,567,625.00	100.0
131001	Улсын төсвөөс санхүүжих	525,272,300.00	507,704,675.00	17,567,625.00	100.0
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	5,029,603,540.50	5,029,603,540.50	-	100.0
	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	5,029,603,540.50	5,029,603,540.50	-	100.0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл				

This image shows a full page of white paper with horizontal dotted lines. The lines are evenly spaced and run across the width of the page, providing a guide for handwriting practice. There are no margins, text, or other markings on the page.

This image shows a full page of white paper with horizontal dotted lines. The lines are evenly spaced and run across the width of the page, providing a guide for handwriting practice. There are no margins, text, or other markings on the page.